

Уламжлалт анагаах, Зүү төөнө заслын эмчийн мэргэшлийн зэрэг олгох тусгай шалгуурууд

1. Ахлах зэрэг олгох шалгалтанд ороход дараах шалгуурыг хангасан байна.Үүнд:

Нийтлэг шалгуур

1.1.1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх.

1.1.2. Эзэмшсэн мэргэжлээрээ 8 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх

1.1.3. Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх

1.1.4. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх

Тусгай шалгуур

1.2.1.Мэргэжлийн ажлаа чадварлаг гүйцэтгэж, эмчилгээ үйлчилгээний дутагдал гаргалгүй ажилласан байна. /чанарын алба, нэгжийн тодорхойлолт /

1.2.2.Уламжлалт анагаах ухаан, Зүү төөнө заслын чиглэлээрээ эрдэм шинжилгээ, эмнэл зүйн ажиглалт, судалгааны ажилд оролцсон байх, илтгэл өгүүлэл 1-2 хэвлэн нийтлүүлсэн байна. /илтгэл, оролцсон судалгааны товч тайлан/

1.2.3.Эмчилгээ, оношлогооны шинэ арга, аргачлал, удирдамжийг 2-оос доошгүйг нэвтрүүлж, үр дүнг гаргасан байна. / тусламж үйлчилгээнд нэвтэрсэн талаар аймаг, НЭ-н ерөнхий эмч, нийгэмлэгийн тэргүүлэгчдийн тодорхойлолт/

1.2.4.Уламжлалт анагаах ухааны эрүүл аж төрөх ёс, өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар хүн амд зөв ойлголт мэдлэгийг төлөвшүүлэх зорилгоор зөвлөмж, удирдамжийг 5-с доошгүйг гаргасан байна. /байгууллага болоод улсын хэмжээнд гаргасан байна./

/ зөвлөмж, удирдамжийн материалыг хавсаргана/

1.2.5.Уламжлалт анагаахын чиглэлээр сурвалж тайлбар зохиолуудыг уншсан байна. /товчлол, тэмдэглэл/

2. Тэргүүлэх зэргийн эмч дараах шалгуурыг хангасан байна.Үүнд:

Нийтлэг шалгуур

2.1.1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх.

2.1.2. Тухайн мэргэжлээрээ ахлах зэрэг авснаас хойш 5 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх.

2.1.3. Магистраас доошгүй боловсролын зэрэгтэй байх

2.1.4. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх

Тусгай шалгуур

2.2.1. Уламжлалт анагаах ухаан, Зүү төөнө заслын тодорхой нэг чиглэлээр мэргэшиж, мэргэжлийн ажлаа чадварлаг гүйцэтгэж, эмчилгээ үйлчилгээний дутагдал гаргалгүй ажилласан байна./ чанарын алба, нэгжийн тодорхойлолт /

2.2.2. Эмчилгээ, оношлогооны шинэ арга, аргачлалыг 3-с дээш эзэмшиж үр дүнд хүрсэн байх ба тухайн салбарын эрдэм судлалын ажлын үр дүнг үйл ажиллагаандаа бүтээлчээр нэвтрүүлсэн байна. /тайлан/

2.2.3.Мэргэжлийн санал дүгнэлт гаргах, сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох /явуулсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, дүгнэлт гаргасан материалыг хавсаргах/

2.2.4. Эрдэм шинжилгээ, судалгааны 5-оос доошгүй бүтээл, гадаад дотоодын хуралд хэлэлцүүлж, хэвлүүлж олны хүртээл болгосон байх /бүтээлийн хуулбар, хэвлүүлсэн материал, судалгааны тайлан, тодорхойлолт/

2.2.5.Уламжлалт анагаах ухааны эрүүл аж төрөх ёс, өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар хүн амд зөв ойлголт мэдлэгийг төлөвшүүлэх зорилгоор зөвлөмж, удирдамжийг 5-с доошгүйг гаргасан байна.

2.2.6. Уламжлалт анагаахын чиглэлээр сурвалж, тайлбар зохиол, уншсан байна. /тэмдэглэл/

3. Зөвлөх зэрэг олгоход дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

3.1.1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байна.

3.1.2.Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байх

3.1.3. Боловсролын докторын зэрэгтэй байх

3.1.4.Мэргэжлээрээ 20 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан одоо тухайн мэргэжлээрээ ажиллаж буй

3.1.5. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх

Тусгай шалгуур

3.2.1.Эрдэм шинжилгээ, судалгааны 5-с доошгүй бүтээл, гарын авлага хэвлүүлж, шинээр болон шинэчлэн боловсруулсан арга зүйг олны хүртээл болгосон байх /судалгааны тайлан, илтгэл, бүтээл, гарын авлагын хуулбар, хэвлүүлсэн материал/

3.2.2.Тухайн мэргэжлийн салбарын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гар бие оролцон, бодлого арга зүйн асуудлыг дэвшүүлж шийдвэрлүүлэн, оролцсон байх

3.2.3.Эмчилгээний шинэ арга аргачлалыг нотолгоожуулан салбарын хэмжээнд хэрэгжүүлсэн байх

Мэргэжлийн зэрэг горилох мэргэжилтний бүрдүүлэх материал

1. Мэргэжлийн зэрэг олгохыг хүссэн хувийн өргөдөл
2. Мэргэжлийн зэрэг горилогчийн бүрэн бөглөж, байгууллагын даргаар баталгаажуулсан маягт
3. Холбогдох мэргэжлийн нийгэмлэгээс гаргасан шалгуур үзүүлэлт хангасныг баталгаажуулсан баримтууд
4. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхийн баталгаажуулсан хуулбар.
5. Мэргэжлийн зэрэг өмнө нь хамгаалсан бол үнэмлэхний эх хувь
6. Нотариатаар баталгаажсан иргэний үнэмлэхний хувь
7. 3x4 хэмжээний зураг 2 хувь